

“Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 02 сарын 16 өдрийн хурлын
06/2023 дугаар тогтоолын хавсралт

БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.ЗОРИГТ

“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. ЗОРИЛГО

1.1 ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны зорилго нь:

- 1.1.1 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албаг тушаалтнуудыг сонгон шалгаруулах бодлогыг боловсруулах
- 1.1.2 Тэдний ажил үүргийн тодорхойлох
- 1.1.3 Үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх

замаар ТУЗ-д хяналт удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Хоёр. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

2.1 Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн саналаар сонгогдож, хурлаас томилогдсон 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх ба хорооны дарга нь хараат бус гишүүн байна.

Гурав. ХУРАЛ

3.1 Хорооны хурал жилд 1-ээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зохион байгуулж болно.

3.2 Хуралд гишүүдийн 2/3 –оос доошгүй нь оролцох бөгөөд биечлэн оролцох боломжгүй бол гишүүн бүр саналаа илэрхийлэх боломж бүрдүүлсэн техник хэрэгсэл ашиглан хурлыг зохион байгуулж болно. Эсвэл бичгээр саналыг нь авч болно.

3.3 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг урьдчилан гаргуулж гишүүн бүр танилцсаны үндсэн дээр хэлэлцэнэ.

3.4 Хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлага, ажилтнууд, гаднын зөвлөгчид оролцож болно.

3.5 Хэлэлцэн асуудлынхаа хүрээнд дүгнэлт, зөвлөмж, удирдамж гаргаж, холбогдох дүрэм, журам батална.

Дөрөв. ХОРООНЫ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД

4.1 Компанийн ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирал болон эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулахад тавигдах шаардлагууд:

- Зайлшгүй шаардлагатай мэдлэг, боловсрол

- Ажлын туршлага
- Хувь хүний зан чанар
- Хараат бус байдлын шалгуурууд

болон залгамж халааны бодлогыг тодорхойлж, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.



4.2 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу нээлтгэй, ил тод зарлах, нэр дэвшигчдийг бүртгэн, урьчилсан байдлаар үнэлж, хараат бус гишүүдийг хуулийн дагуу шаардлага хангаж буй эсэхэд дүгнэлт өгч, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ХЭХ-д оруулна.

4.3 ТУЗ-ийн гишүүний ажлыг жилээр үнэлж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, дахин нэр дэвшүүлэх саналыг оруулах.

4.4 ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаанаас өмнө дуусгавар болгох нөхцөл, журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах.

4. 5 Удирдах албан тушаалтнуудын:

- Ажил үүргийн тодорхойлолт, гэрээний нөхцлийг албан тушаал нэг бүрийн компанийн төлөө оруулбал зохих хувь нэмэрт үндэслэн тодорхойлох
- Ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам боловсруулах
- Ажлын гүйцэтгэлтэй жилд нэг удаа танилцаж дүгнэлт өгөх зэрэг ажлуудыг хийнэ.

Тав. ТАЙЛАГНАЛ БА НУУЦЫГ ХАДГАЛАХ

5.1 Хорооны гишүүд чиг үүргээ биелүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан, эсвэл шалгалтаар илэрсэн аливаа нууц мэдээллийг хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх, шууд болон шууд бус хэлбэрээр бусдад задруулахгүй, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэг хүлээнэ.

Зургаа. ХОРООНЫ ЭРХ МЭДЭЛ

6.1. Хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь эрхтэй байна. Үүнд:

- 6.1.1 Компанийн хэмжээнд баримтлах нэр дэвшүүлэх бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх талаар ТУЗ-д санал зөвлөмж өгөх;
- 6.1.2 Компанийн удирдах ажилтнуудад нэр дэвшүүлэх;
- 6.1.3 Шаардлагатай нөхцөлд ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 6.1.4 ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг үнэлэх, нэр дэвшүүлэх, улируулан томилохтой холбогдуулан шаардлагатай тохиолдолд гадны зөвлөх үйлчилгээ,



хөндлөнгийн шинжээч, хуульч, мэргэжилтний зөвлөгөө авах, тодорхой асуудал дээр хөлсөөр ажиллуулах;

6.4.5 Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зөрчил гаргасан үед арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай үед гүйцэтгэх ажилтны эрхийг түдгэлзүүлэх саналаа ТУЗ-д оруулах;

6.4.6 Энэхүү дүрмийн заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д санал оруулан батлуулах.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ